

"ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨХХК-ИЙН

2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

Тус компанийн 2024 оны дотоод аудитын календарчилсан төлөвлөгөөг 01 дүгээр сарын 17-ны өдөр батлуулсаны дагуу дараах ажил хийгдсэн байна.

1. Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт тавих ажлын хүрээнд Гүйцэтгэх захирал болон Захиргаа удирдлагын хэлтсээс гаргасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой 36 удаагийн А тушаал, 48 удаагийн Б тушаалаар баталсан журам, шийдвэрийн агуулгад хууль, тогтоомжийн нийцлийн аудитыг тавьж ажиллажээ.
2. Албан хаагчдын ажлын байран дахь ёс зүйн дүрмийн хэм хэмжээ, шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан ба иргэд, үйлчлүүлэгч байгууллагаас ажиллагсадтай холбоотой гомдол, санал гараагүй байна.
3. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хөтлөлтөд хуулийн дагуу хяналт тавьж байгаа бөгөөд хоцорсон мэдээлэл байхгүй болно.
4. Үндэсний аудитын газраас 2024 оны санхүүгийн тайланд хийсэн шалгалтаар зөрчил арилгах тухай 5 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн ба үүний дагуу хийсэн ажлын тайланг хавсаргав.
5. ТУЗ-ийн баталсан компанийн 2025 оны зорилтод түвшинд тусгасаны дагуу Бараа, ажил үйлчилгээ авахаар харьцуулалтын болон нээлттэй тендер 8 зарлаж амжилттай болсон ба 2,827.8 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хөрөнгө оруулалтын 9 удаагийн 278,2 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна. Тендерийн болон шууд худалдан авалттай холбоотой гомдол гараагүй болно. Файл хавсаргасан.
6. Хэлтэс, нэгжүүдийн 2024 оны ажлын тайланг Гүйцэтгэх захирлын хурлаар хэлэлцүүлсэн.

Үндэсний аудитын газраас хийсэн аудитын
шалгалтын хүрээнд хийсэн ажлууд

Тус компанийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд Үндэсний аудитын газраас аудит хийж 5 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн. Илэрсэн зөрчил, авсан арга хэмжээг дурдвал:

1. “Туулах чадвар сайтай автомашинаар үйлчилгээ үзүүлэх, төлбөр тооцоо барагдуулах” ЭХЧТ/41/2024 дугаар гэрээг 2024 оны 5 дугаар сарын 02-ны өдөр байгуулж, өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй үйлчилгээнд 28.4 сая төгрөг зарцуулсан зөрчилд “... зөрчлийг таслан загсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны дотор ҮАГ-т ирүүлэх албан шаардлага өгсөн.

Авсан арга хэмжээ: Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж цаашид давтахгүй байхыг Гүйцэтгэх захирал /Д.Бямбасүрэн/, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч /Б.Амараа/, хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор /Л.Даваахүү/ нарт даалгасан.

2. Майнримек ХХК, Блейк стар альфа ХХК, Огмент ХХК, Визлис визарт ХХК, Энхансмент ХХК-тай нэвтрүүлэг, контентын үйлчилгээ авах гэрээг байгуулж, өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй үйлчилгээнд 28.4 сая төгрөг зарцуулсан зөрчилд “... зөрчлийг таслан загсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны дотор ҮАГ-т ирүүлэх албан шаардлага өгсөн.

Авсан арга хэмжээ: Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж цаашид давтахгүй байхыг Гүйцэтгэх захирал /Д.Бямбасүрэн/, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч /Б.Амараа/, хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор /Л.Даваахүү/ нарт даалгасан.

3. Тосны ус болон зунгааралт тодорхойлох 21,6 сая төгрөгийн ижил төрлийн багнийг шууд худалдан авалт хийх зорилгоор баталсан төсвийг хувааж, нэг байгууллагаас худалдан авсан зөрчилд албан шаардлага өгсөн.

Авсан арга хэмжээ: Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж цаашид давтахгүй байхыг Гүйцэтгэх захирал /Д.Бямбасүрэн/, Санхүү бүртгэлийн хэлтсийн

дарга, ерөнхий нягтлан бодогч /Б.Амараа/, хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор /Л.Даваахүү/ нарт даалгасан.

4. Зорилтот түвшинд тусгагдаагүй “Санхүүгийн дүгнэлт гаргуулах”, “Харуул хамгаалалтын ажил үйлчилгээ”-нд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан зөрчилд албан шаардлага өгсөн.

Авсан арга хэмжээ: “Санхүүгийн дүгнэлт гаргуулах” компанийн сонгон шалгаруулалт нь ЭХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн В/3444, Зардал шийдвэрлэх тухай ТУЗ-ийн 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 20 тоот тогтоолыг үндэслэн зарласан бөгөөд Олон улсын санхүүгийн дүгнэлт гаргах эрх бүхий Голден пейж аудит ХХК шалгарсан. Үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулагдаагүй болно. “Харуул хамгаалалтын ажил үйлчилгээ”-нд 2024 оны Бизнес төлөвлөгөөнд 36.0 сая төгрөг туссан байсан ба зорилтот түвшний тодотголоор 48,5 сая төгрөг болсон болно.

5. ЭХҮТ/20240203029 дугаартай “Санхүүгийн дүгнэлт гаргуулах” гүйцэтгэгчийг сонгон тендерийг зарласан боловч шаардлагатай тендерийн бичиг баримт /ажлын даалгавар/-ыг оруулаагүй, тендерийн ерөнхий шаардлага хангаагүй байгууллагыг сонгон шалгаруулсан зөрчилд албан шаардлага өгсөн.

Авсан арга хэмжээ: “Санхүүгийн дүгнэлт гаргуулах” компанийн сонгон шалгаруулалт Олон улсын санхүүгийн дүгнэлт гаргах эрх бүхий аудитортой шаардлага тавьсан ба Голден пейж аудит ХХК ганцаар оролцож шалгарсан. Энэ компанийн татвар, НДШ-ийн төлөлтийн талаар нэмэлт тодруулга авсан. Санхүүгийн дүгнэлт гаргуулахаар хүсэлт гаргасан Япон болон Монгол улсын 3 компанийн консерциум нь санхүүгийн мэдээллийн нууцыг ажлын даалгаварт тусгах боломжгүй байсан ба зөвхөн шалгарсан компанид дүгнэлт гаргахад шаардагдах материалаа гаргаж өгөх байсан болно. Үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулагдаагүй болно.

Үндэсний аудитын газрын 2024 оны санхүүгийн тайлангийн шалгалтаар ирүүлсэн ЗӨВЛӨМЖ

1. Тайлант онд шатахууны замын хуудас байхгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байгаа зөрчилд Шатахууны жолоочийн замын хуудастай болох, анхан шатны баримтын иж бүрдлийг хангах зөвлөмж өгсөн.

Авсан арга хэмжээ: Зөвлөмжийн дагуу Замын хуудасны маягтыг шинээр боловсруулж, Захиргаа, удирдлагын хэлтэс, Санхүүгийн хэлтэс, Аж ахуй алба хамтарч жолоочийн автомашин ашиглалт, түлш, шатахууны тооцоо, түүнийг замын хуудастай уялдуулан хянаж байгаа болно.

2. Тус төв нь 2024 оны жилийн эцсийн байдлаар 890 нэр төрлийн 3,722.8 сая төгрөгийн хөрөнгө элэгдлээрээ өртгөө бүрэн нөхөж ашиглалтын хугацаа дууссан байна. Эрх бүхий байгууллагад хандаж хүсэлт гарган асуудлыг шийдвэрлүүлэх зөвлөмж өгсөн.

Авсан арга хэмжээ: Зөвлөмжийн дагуу компанийн Өмч хамгаалах зөвлөлөөс ТУЗ-ын хуралд хэлэлцүүлж дэмжиж, шийдвэрийг ЭХЯ-ны Санхүүгийн хэлтсээр дамжуулж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүсэлт гаргасан.